

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗАРТ 2016 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхэлж буй тус Хорооны зохицуулалттай байгууллагууд болох үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн байгууллагуудын харилцагч, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд судалгаа, дүн шинжилгээг хийлээ.

Тайлант хугацаанд Хяналт шалгалтын газарт нийт 160 өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс салбар тус бүрээр ангилбал:


Үнэт цаасны салбарт – 52

Даатгалын салбарт – 86

Бичил санхүүгийн салбарт – 22 өргөдөл, гомдол тус тус ирүүлсэн байна.

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг салбар тус бүрээр графикаар харуулбал:

График 1



1. Үнэт цаасны салбарт ирүүлсэн өргөдөл, гомдол:


Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой нийт 52 өргөдөл, гомдол ирсэн.

Дээрх өргөдөл, гомдолд хувьцаат компанийн ногдол ашиг, хувь болон үйл ажиллагаатай холбоотой, үнэт цаасны бүртгэлтэй холбоотой, брокер, дилерийн компаниар

эзэмшигчийн зөвшөөрөлгүй зарагдсан хувьцаатай холбоотой өргөдлүүд дийлэнх хувийг эзэлж байна.

Нийт ирсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь ангилвал:

График 2



Харилцагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж дараах мэргэжлийн оролцогч байгууллагуудад харилцагчдын хохирлыг барагдуулах үүрэг өгч заасан хугацаанд үүргийн биелэлтийг ирүүлж ажиллаж байна.

Хүснэгт 1 /төгрөгөөр/


№	Компанийн нэр	Хохирлын дүн	Төлөгдсөн хохирлын дүн
1	"Санар" ХХК	2,110,952.00	-
2	"Бумба талтай" ХХК	11,500.00	11,500.00
3	"Батс" ХХК	20,000.00	20,000.00
4	"Аргай бэст ҮЦК" ХХК	4,210,000.00	4,210,000.00
	Нийт	6,352,452.00	4,241,500.00

2015 онд харилцагчдын хохирлыг барагдуулахаар мэргэжлийн оролцогч компаниудад 24,748,120.00 төгрөгийг төлүүлэх үүрэг өгснөөс 13,402,740.00 төгрөгийг төлүүлж нэг харилцагчийн 11,335,000.00 төгрөгийг төлүүлэхээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. 2016 оны байдлаар гурван иргэний 2,142,452.00 төгрөгийг харилцагч, хөрөнгө оруулагчдад төлүүлэхээр үүрэг өгсөн.


Үнэт цаасны салбарт ирж буй нийт өргөдлийн 59 хувь нь эзэмшигчийн зөвшөөрөлгүй хийгдсэн арилжаа эзлэж байгаа бөгөөд үүнээс 50 хувь нь тус Хорооны тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй нэр бүхий 10 брокер, дилерийн компаниудаар дамжуулан арилжаалагдсан бол үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон 7 брокер, дилерийн компаниар дамжуулан хийгдсэн гэх өргөдөл, гомдол 50 хувийг эзэлж байна.

Дээрх зөвшөөрөлгүй арилжаалагдсан гэх үйлдэл нь 1996 оноос 2008 онуудад хийгдсэн байх бөгөөд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үнэт цаасны компаниудад хандан ирүүлсэн нийт өргөдөл, гомдлыг доорх графикаар харууллаа:

График 3



Өмнө нь үнэт цаасны зах зээл дээр тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байсан одоо тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон үнэт цаасны компаниудад хандан ирүүлсэн өргөдөл, гомдлыг хувьчлан харуулбал:



Мөн хувьцаат компанийн бүртгэл болон хаяг байршил, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэртэй холбоотой асуудлаар, ногдол ашгийн талаарх мэдээлэл авахыг хүссэн өргөдөл, гомдлууд аж ахуй нэгж болон иргэдээс ирүүлсээр байна.


2. Даатгалын салбарт ирүүлсэн өргөдөл, гомдол:

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 262 дугаар тогтоолоор батлагдсан тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд даатгалын салбарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас даатгалын үйл ажиллагаатай холбоотой маргаан 2016 оны 01 дүгээр улирлын байдлаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 86 ирж шийдвэрлэгдсэн бөгөөд даатгалын төрлүүдээр авч үзвэл Жолоочийн хариуцлагын албан журмын, Автотээвэр буюу Тээврийн хэрэгслийн, Орон сууц, зээлдэгчийн амь насны, Тээвэрлэгчийн хариуцлагын, Ажилчдын гэнэтийн осолын, Бизнес эрхлэгчдийн цогц даатгал, Гэрлэлтийн улсын даатгалын төрлүүдээр мөн даатгалын хохирол үнэлгээний тайлан, дүнг шалгуулах, тус Хорооноос батлагдсан дүрэм, журмыг хэрхэн ойлгох талаар Даатгалын компаниудаас ирүүлсэн хүсэлтүүдийг хуулийн дагуу урьдчилан шийдвэрлэж нийт 86,704,480.00 (наян зургаан сая долоон зуун дөрвөн мянга дөрвөн зуун наяд) төгрөгийн даатгалын нөхөн төлбөрийг барагдуулан ажилласан байна.

Даатгалын салбарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдлыг графикаар харьцуулж харуулбал. Үүнд:

2016 оны 01 дүгээр улиралд ирсэн өргөдөл, гомдлын харьцааг давхардсан тоогоор харуулав.

2016 оны нэгдүгээр улиралд ирсэн өргөдөл, гомдлын харьцааг давхардсан тоогоор харуулав.



2015 оны байдлаар даатгалын нийт компаниуд 1,030,814 иргэн, албан байгууллагатай даатгалын гэрээ байгуулж ажилласанаас 66,012 даатгалын гэрээнд холбогдох нөхөн төлбөр олгосон байна.


Нийт байгуулсан гэрээг даатгалын бүтээгдэхүүний төрлүүдээр нь харуулав

Хүснэгт 1.

№	Даатгалын хэлбэр	2015.12.31-ны байдлаар Нөхөн төлбөр авсан гэрээний тоо
1	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	9826
2	Хөрөнгийн даатгал	3200
3	Автотээврийн хэрэгслийн даатгал	15787
4	Ачааны даатгал	37
5	Барилга угсралтын даатгал	3
6	Мал амьтдын даатгал	68
7	Агаарын хөлгийн даатгал	0
8	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	27
9	Хариуцлагын даатгал	531
10	Санхүүгийн даатгал	353

11	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	33329
12	Зээлийн даатгал	495
13	Итгэлцлийн даатгал	2
14	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	13
15	Хугацаат амьдралын даатгал	148
16	Хуримтлалын даатгал	37
17	Тэтгэврийн даатгал	11
18	Эрүүл мэндийн даатгал	2145
	Нийт	66012

ХШГ-т ирсэн өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүний төрлөөр харуулав



2015 онд даатгалын салбарт даатгалын тохиолдлын улмаас нийт 66012 даатгалын гэрээнд 36.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ.

Санхүүгийн зохицуулах хороонд 2016 оны 01 дүгээр улиралд иргэн, аж ахуйн, нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд хугацаанд нь урьдчилан шийдвэрлэж нийт 86,704,480.00 (наян зургаан сая долоон зуун дөрвөн мянга дөрвөн зуун ная) төгрөгийг төлүүлэн хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалж ажилласан байна.


- Талуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэж нөхөн төлбөр төлүүлсэн дүнг Даатгалын компани бүрээр гаргаж доор хүснэгт 1 харуулав.

№	Компанийн нэр	Төлөгдсөн нөхөн төлбөрийн дүн
1	"Ард даатгал" ХХК	28,292,000.0
2	"Бодь даатгал" ХХК	3,177,200.0
3	"Мандал Женерал даатгал" ХХК	5,900,500.0
4	"Монре даатгал" ХХК	10,792,000.0
5	"Монгол даатгал" ХХК	9,989,500.0
6	"Миг даатгал" ХХК	28,553,280.0
	Нийт	86,704,480.0

3. Бичил санхүүгийн салбарт хандан ирүүлсэн өргөдөл, гомдол:

Тайлант хугацаанд бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой нийт 22 өргөдөл гомдол ирүүлснээс банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 9, хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотой 11, бусад үйл ажиллагаатай холбоотой 2 өргөдөл, гомдол тус тус ирсэн байна.

График 8



2016 оны нэгдүгээр улиралд нийт ирсэн өргөдөл гомдлын дийлэнх хувийг ХЗХ-той холбоотой өргөдөл гомдол эзэлсэн байна.

Бичил санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудад хандан ирүүлж буй өргөдөл, гомдлын тоо бусад хоёр салбартай харьцуулбал бага боловч энэ улиралд

ирсэн өргөдөл гомдлын тоог 2015 оны 3 болон 4 дүгээр улиралд тус салбартай холбоотой иргэдээс ирсэн өргөдөл гомдлын тоотой харьцуулахад 25%-р өссөн үзүүлэлттэй байна.

График 9



СЗХ нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага тул иргэд, хуулийн этгээд, хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчдээс хувьцаат компанийн ногдол ашиг болон хувьцаа зөвшөөрөлгүй зарагдсан тухай, даатгалын компаниудын нөхөн төлбөр болон бичил санхүүгийн байгууллага тэдний үйл ажиллагаатай холбоотой ирсэн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хүрээнд хянан шийдвэрлэдэг болно.

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ,
ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ХЭЛТЭС**